ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр Дугаар А/319 Арвайхээр сум

Сууц өмчлөгчдийн холбоонд орчны газрыг ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, $44^1$ дүгээр зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арвайхээр сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах нийтийн орон сууцны орчны 3350$м^2$ газрыг Онги-Өргөө сууц өмчлөгчдийн холбоонд хавсралтаар ашиглуулсугай.

2.Орчны газар ашиглах эрх авсан сууц өмчлөгчдийн холбоотой газар ашиглуулах гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/365 дугаар захирамжийн хавсралтын Б.Сангисүрэнтэй холбогдох хэсэг, “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/336 дугаар захирамжийн хавсралтын Б.Сангисүрэнтэй холбогдох хэсэг, “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай” 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А/379 дүгээр захирамжийн хавсралтын Б.Сангисүрэнтэй холбогдох хэсэг, “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/331 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

5223 11 0610

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 16-ны өдрийн А/314 дугаар
захирамжийн хавсралт

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ БҮХИЙ ГАЗАРТ
ГАЗАР АШИГЛАХ ХУУЛИЙН ЭТГЭЭД

| Д/д | Газар ашиглах хуулийн этгээдийн нэр | Регистрийн дугаар | Газрын хэмжээ ( $м^2$) | Газрын зориулалт | Газрын байршлын хаяг, нэр | Хугацаа (жил) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Онги-Өргөө сууц өмчлөгчдийн холбоо | 9902899 | 3350 | Олон нийтийн байгууллага | 13 дугаар баг, Т.Намнансүрэн-3 дугаар гудамж 301 дүгээр байр (32 айлын 3 байр) | 5 |
| | Дүн | | 3350 | | | |

-оОо-